БАТЛАВ:

СОНГИНО СУМЫН ЗАСАГ ДАРГА

С.ГАНЗОРИГ

ЗАВХАН АЙМГИЙН СОНГИНО СУМЫН ТӨВИЙН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЭСЭГЧИЛСЭН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар ЕТ-01/2025

2025.03.10 өдөр **Сонгино сум**

1	Ерөнхий төлөвлөгөө боловсруулах үндэслэл	- Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.8, 7.1.9, 9.1.4 дэх заалт; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа - 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хөгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 3.6.1; - Сонгино сумын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Сонгино сумын 2025 оны "Жилийн хөгжлийн төлөвлөгөө";
2	Байршил, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал	**Байршил:** Завхан аймгийн Сонгино сум нь 1924 онд байгуулагдсан. Завхан аймгийн баруун хойд хэсэгт оршдог Улаанбаатар хотоос 1035 км, Аймгийн төвөөс 282 км зайд байрладаг. Завхан аймгийн Баянхайрхан, Түдэвтэй, Цэцэн уул, Сантмаргаз, Увс аймгийн Зүүнхангай сумтай хиллэдэг.Нийт 248,953 га нутагтай, сумын төв нь Цавдан, Айраг нуур, Шар нуруу, Тариат, Баян-Айраг, Бор-Өндөр зэрэг 5 баг, 498 өрх, 1600 хүн амтай, 115,000 малтай. **Эдийн засаг:** Сумын хэмжээнд 54 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлдэг. **Зам тээвэр:** Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон. **Цахилгаан хангамж:** Алтай-Улиастай эрчим хүчний системд холбогдсон. **Усан хангамж:** Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн 7 гүний худаг. Албан газрууд цэвэр усны шугамд холбогдсон. **Дулаан хангамж:** Сумын төв халаалтын нэгдсэн системд холбогдсон. **Орон сууцны хангамж:** Сумын хэмжээнд инженерийн бүрэн хангамжтай орон сууц байхгүй. **Боловсрол:** Ерөнхий боловсролын 12 жилийн сургууль 2022 онд ашиглалтад орсон 320 хүүхдийн хичээлийн байртай, 16 бүлгийн 329 хүүхэд өдрөөр суралцаж байна.1982 онд баригдсан дотуур байранд малчдын 35 хүүхэд амьдардаг, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтад 3 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 100 хувь, суурь боловсролын хамран сургалт 100 хувьд хүрсэн.Төрийн өмчийн цэцэрлэг 16 ажилтантай,4 бүлэгт

		119 хүүхэд хамрагдаж, сургуулийн өмнөх боловсролын хамралт 100 хувьд хүрсэн. **Эрүүл мэнд:** Эрүүл мэндийн төв Бор-Өндөр багт байршилтай 2019 онд ашиглалтад орсон блокон дүүргэлттэй бетонон хийцтэй зориулалтын барилга байгууламжид үйл ажиллагаа явуулдаг.10 ортой 2 эмч, 5 сувилагч нийт 21 ажилтантай.
3	Хамрах хүрээ, газар нутгийн хэмжээ (га)	Төлөвлөлт хийх газрын хэмжээ 640 га. /Төлөвлөлт хийх газрын хил, хязгаарыг захиалагч, орон нутагтай харилцан тохирно/ Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн шийдэлд тулгуурлан талбайн хэмжээг нарийвчлан тогтоож, орон нутагтай хэлэлцэн нэг байршилд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулна.
4	Боловсруулах ажлын үе шат	Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа дараах үе шатны дараалаар хийнэ. Үүнд: а.Хот байгуулалтын суурь судалгаа /байр зүйн дэвсгэр зураг, инженер-геологийн судалгааг шаардлагатай хэсэгт хийх. /Ажлын даалгаврыг гүйцэтгэгч нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай заавал зөвшилцөнө./ Нутаг, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтцийн судалгаа болон бусад судалгаа/-г 2025 оны байдлаар хийх; б.Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ; в. Төлөвлөлтийн үндсэн шийдэл, боловсруулалт; г. Ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын төвийг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө; д. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах шаардлагатай тохиромжтой байршлыг судлан, сонгож захиалагч байгууллагатай зөвшилцөж боловсруулна.
5	Ерөнхий төлөвлөгөө боловсруулахад ашиглах материал	**Монгол Улсын хуулиуд:** - Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль; - Хот байгуулалтын тухай хууль; - Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Орон сууцны тухай хууль; - Барилгын тухай хууль; - Газрын тухай хууль; - Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль; - Геодези, зураг зүйн тухай хууль; - Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Усны тухай хууль; - Хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай болон бусад хууль тогтоомж; **Бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүд:** - "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг; - "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл";

		- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; -"Ус үндэсний хөтөлбөр", "Ус үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" Монгол Улсын Их Хурлын 2010 оны 24, 304 дүгээр тогтоол; -"Ногоон хөгжлийн бодлого" Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоол; - "Төрөөс ойн талаар баримтлах бодлого" Монгол Улсын Их Хурлын 2015 оны 49 дүгээр тогтоол; - "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр" Засгийн газрын 2005 оны 32 дугаар тогтоол; - "150 мянган айл-Орон сууц" үндэсний хөтөлбөр" Засгийн газрын 2019 оны 202 дугаар тогтоол; - Салбаруудын хэмжээнд хэрэгжиж буй дотоодын болон олон улсын төсөл, хөтөлбөрүүд; **Норм норматив, стандарт:** - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм (БНбД 30-01-04); - Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах заавар (БД 30-103-21); - Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09); - Хот, тосгонд улаан шугам төсөллөх ба тогтоох заавар (УББ 30-202-11) - Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл (БНбД 11-07-19); - Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07); - Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм; (ЗТБХБ-ын сайдын 2011 оны 226 дугаар тушаал) - "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам" /ЗТБХБ-ын Сайдын 183 дугаар тушаал/; - MNS 3237:1989 Ерөнхий төлөвлөгөө. Зам тээврийн таних тэмдэг, дүрслэл; - MNS 5873:2008 Барилгын зураг. Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэглэгээ; - MNS ISO 11091: 2007 Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах; - MNS 6925-13:2021 Газар зүйн мэдээлэл. Түүх, соёл, археологийн өвийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт; - MNS 6925-15:2021 Газар зүйн мэдээлэл. Хаягийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт; - MNS 6925-9:2021 Газар зүйн мэдээлэл. Инженер-геологийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт. - MNS 6925-8:2021 Газар зүйн мэдээлэл. Зам тээврийн сүлжээний өгөгдлийн үзүүлэлт; - MNS 6925-7:2021 Газар зүйн мэдээлэл. Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт; - MNS 6925-4:2021 Газар зүйн мэдээлэл. Газар ашиглалтын орон зайн өгөгдлийн үзүүлэлт; - Бусад холбогдох норматив баримт бичиг, стандартууд;

6	Баримт бичгийн бүрдэл	**Хот төлөвлөлтийн суурь судалгаа:** -"Хот байгуулалтын тухай" хуулийн 12.9 дэх хэсэг болон холбогдох хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичгийн дагуу /инженер-геологи, байр зүйн зураглал, газар нутаг, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтцийн судалгаа болон бусад судалгааны тайлан г.м/ боловсруулна. Байр зүйн зургийг дараах зориулалтын дагуу боловсруулна: - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө М1:5000 - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө М1:1000 -Инженер-геологийн судалгаа /төлөвлөлтөд хамрагдах нийт талбайн хэмжээнд/ - Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ **Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө:** Зураглал; - Хот орчмын бүсийн хөгжлийн тойм, нутаг дэвсгэрийн байршлын схем М1:25000 - Одоогийн байдал орчны тойм зураг М1:5000 - Макет М1:1000, 3D хэмжээст график болон хөдөлгөөнт зураглал, файлаар/видео анимейшн/ **Архитектур орон зайн төлөвлөлтийн зураглал:** - Бүс нутгийн дэд бүтцийн сүлжээнд холбогдсон байдал, байршлын тойм зураг М1:5000; - Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний зураг М1:2000; - Ерөнхий төлөвлөгөөний үндсэн зураг М1:2000; - Нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэлийн зураг М1:2000; **Газар зохион байгуулалт: /М1:2000/** - Газар зохион байгуулалт ; - Эхний ээлжийн төлөвлөлт ; **Зам, тээврийн сүлжээ: /М1:2000/** - Гудамж, замын сүлжээ; - Нийтийн тээврийн сүлжээ; - Дугуйн замын сүлжээ; - Авто замын ус зайлуулах сувгийн сүлжээ; - Авто замын тэнхлэгийн улаан шугамын төлөвлөлт; **Инженерийн дэд бүтцийн хангамж: /М1:2000/** - Инженерийн хангамжийн эх үүсвэрүүд, шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт - Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам; - Дулаан хангамж; - Цахилгаан хангамж; - Усан хангамж; - Ариутгах татуурга; - Холбоо мэдээлэл; - Сэргээгдэх эрчим хүч; - Хийн хангамж ; - Камерын нэгдсэн сүлжээ; **Цэцэрлэгжилт, ногоон байгууламж:/М1:2000/** - Цэцэрлэгт хүрээлэн, парк; - Тохижилт, ногоон байгууламж; - Гол, нуур, усан толио, цөөрмийн төлөвлөлт;

		Нийгмийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт /М1:2000/ - Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, худалдаа, үйлчилгээ; - Архитектур, түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийн хамгаалалт, төлөвлөлт төлөвлөлт; **Гамшгийн менежментийн төлөвлөлт:/М1:2000/** - Гал унтраах автомашиныг усаар цэнэглэх гадаргын ус хуримтлуулах нуур, цөөрөм, гудамж замын гидрант; - Түр хоргодох байр, цуглах талбай, дуут дохио; - Нүүлгэн шилжүүлэх, авран хамгаалах; Аялал жуулчлалын менежмент; Хог хаягдлын менежмент; /М1:2000/ **Суурьшлын бүсийн дахин төлөвлөлт:/М1:2000/** - Гэр хорооллын дахин төлөвлөлт; - Газар шинэчлэн зохион байгуулалт; **Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө:** - Хөгжлийн чиг хандлага - Өнөөгийн байдлын судалгаа; - Эдийн засгийн тооцоо хүн ам, орон сууцны хангамж, нийгмийн үйлчилгээ; - Гудамж, зам тээврийн төлөвлөлт; - Явган хүний замын хөдөлгөөний схем; - Авто замын тэнхлэгийн улаан шугамын төлөвлөлт, зай хэмжээ; - Төлөвлөлтийн үндсэн шийдэл; - Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж; - Зам, талбайн өндөржилт, төлөвлөлт, инженерийн бэлтгэл ажил; - Инженерийн хангамж эх үүсвэр, шугам сүлжээ; - Эхний ээлжийн барилгажилт, газар зохион байгуулалтын төлөвлөлт; **Тайлбар бичиг:** - Ерөнхий төлөвлөгөө хийгдэх талбайд 1:500 масштабтай байр зүйн зураглалын ажил хийнэ - Геодезийн ажил гүйцэтгэх цаг хугацааны үеийн өндөр нарийвчлалын 1:1000-ны масштабтай тоон агаарын дэвсгэр зураг хийх - 1:1000-ны масштабтай байр зүйн зургийн нарийвчлал хангасан нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр авсан ортофото зураг, (нарийвчлал нь GSD 0.01-0.05) **Тайлбар бичиг:** - Ерөнхий төлөвлөгөө боловсруулсан үндэслэл, зорилго, хамрах хүрээ, бүрэлдэхүүн, аргачлал, арга зүй, ажлын төлөвлөгөө, хуваарь; - Хот байгуулалтын суурь судалгаа, дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, харьцангуй давуу, сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо болон өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд өгсөн үнэлэлт, дүгнэлт; - Орон зайн төлөвлөлтийн үндсэн шийдэл;

		- Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг гаргах, ээлж дараалыг төлөвлөлтийн үе шатны дагуу тогтоох, хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийн тооцоог хийх г.м/; - Эхний ээлжинд хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтцэд шаардагдах хөрөнгө оруулалтын хөтөлбөр; - Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт; - Хүрээлэн буй орчин болон түүх, соёл, уран барилгын дурсгалыг хамгаалах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө зэргийг нарийвчлан гаргаж, төлөвлөлтийн холбогдох зураг, зургийн даалгавар зэрэг материалыг хавсаргана. - Тайлбар бичиг, хөрөнгө оруулалтын тооцоо; **Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө:** - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих томоохон төсөл, арга хэмжээний байршлын бүдүүвч зураг; **Товч танилцуулга:** - Хэвлэлийн эх бэлтгэл, цаасны формат /сонголтоор/ - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хураангуй; - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хураангуй; - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний онцлог давуу талыг тусгасан хурлын тараах материал; - Олон нийтэд зориулсан тараах материал /брошюр/; Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалтын нэгдсэн мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага: 1.Бичиглэлийн баримт бичиг -Тайлбар бичиг /*.doc, *.pdf, *.xlsx / ; -Батлагдсан баримт бичиг скайнер /*.pdf, *.jpg/; 2.Зураглалын баримт бичиг -Ажлын файл /*.dwg, *.shp, *.skp, lumion, *.max, *.cdr/; -Батлагдсан баримт бичиг скайнер /*.jpg, *.pdf/; 2.Товч танилцуулга -Олон нийтийн хэлэлцүүлэг, хурлын танилцуулга /*.ppt/; Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эхлэлийн, дундын, эцсийн тайлангийн хугацаанд бичиглэлийн баримт бичгийг А4, зураглалын баримт бичгийг А1 форматаар 1% захиалагчид, улсын экспертизийн дүгнэлт гарч, эрх бүхий байгууллагаар батлагдсан хот байгуулалтын баримт бичгийг орон нутгийн архивт эх хувиар 1%, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тус бүр хуулбар 1% үйлдэж цаасан хэлбэрээр хүлээлгэн өгнө. Хот байгуулалтын баримт бичгийг тоон байдлаар DVD дээр бичиж хүлээлгэж өгөх: Үүнд: - Байр зүйн дэвсгэр зураг, инженер-геологийн судалгааны тайлан /*doc, зураглал *dwg/; - Ерөнхий төлөвлөгөөний файл /*dwg, *shp/; - Зураглалын материал /*jpeg/; - Тайлбар бичиг /*pdf, *word/; - Холбогдох хурлын тэмдэглэл, шийдвэр скайнердсан /*doc, *pdf;/

		- Зөвшөөрөлцсөн байгууллагын шийдвэр скайнердсан /*pdf/; - Улсын экспертизийн дүгнэлт скайнердсан /*pdf/; - Батлагдсан шийдвэр скайнердсан /*pdf/ тус тус хуулж 3 хувь бэлтгэж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Аймгийн Засаг даргын тамгын газар, тухайн орон нутгийн аймгийн Архив, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газарт тус бүр хүлээлгэж өгнө. - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д нэвтрэх эрх авч баримт бичгийг төслийн шатанд оруулан холбогдох байгууллагаас цахимаар санал авах, батлагдсаны дараа эцсийн байдлаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний орон зайн мэдээллийг цахим системд оруулна.
7	Төлөвлөлтөөр шийдвэрлэх үндсэн асуудлууд	- Аймаг, сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, бүлэг суурингийн тогтолцоотой уялдуулан, орон нутгийн хөгжлийн онцлог, нөөц боломжид тулгуурлан төлөвлөлтийн шийдлийг гаргах; - Төвийн хэсгийн барилгажилт, тохижилт, орон зайн архитектурын шийдлийг тусгайлан авч, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулна. /Төв зам дагуух явган зам талбай, гэрэлтүүлэг, ногоон байгууламж, барилгажилтыг тусгана/ - Тухайн орон нутгийн , байгаль цаг уур, газар зүйн нөхцөл, нийгэм эдийн засгийн онцлогийг тусгасан барилгажилт, барилгажилт, тохжилт бүхий орон зайн бүтэцтэй хот төлөвлөлт, архитектурын онцлог шийдлийг гаргах; - Инженер-геологийн нөхцөлөөс хамааруулан инженерийн бэлтгэл арга хэмжээг иж бүрнээр төлөвлөх; - Хотын нутаг дэвсгэрийг байгалийн аюултай үзэгдэл, гамшигт өртөж болзошгүй эрсдлийн зэргээр нь ангилан бүсчилж, урьдчилан сэргийлж хамгаалах арга хэмжээг төлөвлөх; - Олон нийт, соёл, үйлчилгээний төв нь барилгажилтын хувьд харилцан уялдаа сайтай, орон зайн харьцаа, архитектур төлөвлөлтийн хувьд цогцолбор байх чиглэлийг баримтлах; - Одоо байгаа сууршлыг эдийн засаг, нийгмийн дэд бүтэцтэй уялдуулан нягтруулан төлөвлөнө; - Орон сууц, цэцэрлэг, сургууль эмнэлэг, соёл, ахуй үйлчилгээний төв, зэрэг байгууламжийн хүчин чадлыг нарийвчлан тогтоох; - Норм, дүрмийн дагуу ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, амрах талбай, авто машины зогсоолыг төлөвлөх; - "Хот байгуулалтын тухай" хуулийн 13 дугаар зүйлд заасан бүсчлэлийг хот байгуулалтын норм ба дүрмийн дагуу төлөвлөх; - Газар өмчлөл, эзэмшлийн талаарх судалгааг хийж цаашид олгох газрыг бүсчилэн тогтоож, ерөнхий төлөвлөгөөнд тусгах;

		- Ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний эхний ээлжийн төлөвлөгөөг сумтай хамт боловсруулан ерөнхий төлөвлөгөөтэй хамт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах; - Хог хаягдлын цэг, талбайг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн төлөвлөх, байршил, хэмжээг тогтоож, төлөвлөлтийн зурагт тодорхой харуулах; **Инженерийн бэлтгэл арга хэмжээ:** - Инженерийн бэлтгэл ажлын арга хэмжээг хотын нутаг дэвсгэрийн инженер-геологи, гидрогеологийн нөхцөлийн өөрчлөлт, газар зохион байгуулалт, ашиглалтын байдлаас хамааруулан төлөвлөнө. - Уруйн (шар усны аюул, үер) аюултай бүсэд барих барилга байгууламжийг хамгаалахын тулд ой модыг хамгаалах, мод сөөг тарьж ургуулах, хиймэл нуурын байгууламж барих, голын эрэгт далан хаалт хийж бэхлэх, уруйн урсгалыг тогтоох инженерийн барилга байгууламжуудыг төлөвлөнө. ***Ногоон байгууламж:*** - Хотын экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан ногоон, ухаалаг технологийг нэвтрүүлэх, төлөвлөх; - "Ногоон хот" шийдлийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үндсэн зарчимд тусгах төлөвлөх; - Гэр хорооллын нутаг дэвсгэрт томоохон хэмжээний цэцэрлэгт хүрээлэн, ногоон коридоруудыг төлөвлөх; - "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд хэрэгжих боломжтой байршлыг тодорхойлох; ***Дэд бүтцийн хөгжил:*** - Усны эх үүсвэрийн нөөц, эрэлт хэрэгцээний судалгаанд үндэслэн ус түгээх, дамжуулах, хадгалах, цэвэршүүлэлтийн нэгдсэн сүлжээний төлөвлөлтийг боловсруулах; - Одоогийн инженерийн дэд бүтцийн хангамжийн эх үүсвэрүүд болон сэргээгдэх эрчим хүч, байгалийн өөрийнх нь нөөцийг ашигласан орчин үеийн дэвшилтэт технологийн дагуу инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг боловсруулах; - Дулаан хангамж, усан хангамж, ариутгах татуурга, цахилгаан холбооны эх үүсвэр, инженерийн хангамжийн одоогийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч цаашдын хөгжлийн төлөв, хэрэгцээтэй уялдуулан тооцож үндсэн шийдлийг тодорхойлох, хэрэгжүүлэх ээлж дараалыг тогтоох; - Одоогийн инженерийн шугам сүлжээний алдагдалыг багасгах, төвлөрсөн болон хэсэгчилсэн системтэйгээр төлөвлөлтөнд тусгах - Инженерийн хангамжийг техникийн оновчтой шийдлийн дагуу эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт, байгаль орчинд ээлтэй технологитой байхаар төлөвлөх; ***Зам, тээврийн сүлжээ:*** - Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын трассыг төлөвлөлтөд тусгах;

8	Орон сууцны хангамж	-Нийтийн орон сууцны хотхон, 1-2 давхар эдлэн газартай орон сууц төлөвлөнө. -Эхний ээлжинд инженерийн бүрэн хангамж бүхий 210 айлын амины орон сууцны хороллын хэсэгчилсэн төлөвлөлтийг хийнэ. -Гэр хороллын байршил, газар зохион байгуулалтыг боловсронгуй болгох, гэр хороололд нийгмийн болон инженерийн дэд бүцийн үйлчилгээг ойртуулах, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах асуудлын талаар санал боловсруулж, төлөвлөлтөнд тусгах
9	Баримт бичиг боловсруулах хугацаа	Гэрээнд заасан хугацаанд 2026-2046
10	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Орон нутгийн хөгжлийн сангийн төсөв
11	Захиалагч байгууллага	Завхан аймгийн Сонгино сумын Засаг даргын тамгын газар
12	Гүйцэтгэгч байгууллага	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу сонгон шалгаруулж гүйцэтгүүлнэ
13	Зөвшөөрөлцөх байгууллага	- "Хот байгуулалтын тухай" хуулийн 17 дугаар зүйл, "Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ын дагуу ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтэд танилцуулах, саналыг авах, төлөвлөлтийн шийдлийг аймаг, сум, хотын захиргаа, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар болон бусад холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэх; - Ерөнхий төлөвлөгөөний дунд шатны болон эцсийн шатны тайланг Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх; - Ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд экспертиз хийлгэх; - Ерөнхий төлөвлөгөөний зураг төслийг салбарын Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх. - ХОТ байгуулалтын тухай хуулийн 8.1.5-д заасны дагуу ерөнхй төлөвлөгөөг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулах;
14	Онцгой нөхцөл	**Төлөвлөлтийн хугацаа: 2026-2036 он (Эхний ээлжийн төлөвлөлт 2036-2046 он;** -Нутаг дэвсгэрийн бүсчлэлийг тогтоож, хотжилтыг хязгаарлах нутаг дэвсгэрийг тодорхойлох; /үйлдвэрийн бүс, орон сууц хороолол, төвийн бүс, амралт зугаалгын бүс г.м/ -Инженерийн шугам сүлжээ болон зам тээврийн, усны эрүүл ахуйн, эрчим хүчний хамгаалалтын зурвас газрыг тогтоох;

		-Ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, спорт амралт, хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоолын талбайн хэмжээг нэмэгдүүлэх; -Төлөвлөлтийн шийдлийг үе шатаар хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон, хөрөнгө оруулалтын тооцоог гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх санал боловсруулах; - Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх арга зүй, аргачлалын талаар сумын ЗДТГ, Ерөнхий архитектор, ГХБХБГ–ын мэргэжилтнүүд, инженерийн шугам сүлжээгээр хангагч байгууллагуудад зориулсан сургалтыг гүйцэтгэгчээс хариуцан хийх 2-3 удаа зохион байгуулах.

ХЯНАСАН:

ЗАВХАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ, БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Э.БАЛЖИННЯМ

ЗАВХАН АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР Х.ДЭЛГЭРДАЛАЙ

БОЛОВСРУУЛСАН:

СОНГИНО СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Ч.МЯНГАНБАЯР

ЗАВХАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Ц.АЛТАНГЭРЭЛ

СОНГИНО СУМЫН ГАЗРЫН ДААМАЛ Д.МӨНХЗУЛ